МЭДЭЭ · 2019 оны 12-р сарын 26

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРААС "ШИЛДЭГ ПРОКУРОР" ТОДОРЛОО



Монголын Хуульчдын холбооноос жил бүр уламжлал болгон зохиогддог "Фемида-2019" шилдэг хуульч шалгаруулах ёслолын ажиллагаа 2019 оны 12 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдаж, энэ оны шилдэг хуульчдыг тодруулжээ.

2019 оны “ШИЛДЭГ ПРОКУРОР”-оор Баянзүрх дүүргийн прокурорын газрын ерөнхий прокурорын орлогч А.Бямбацэемаа шалгарч Монголын Хуульчдын холбооны “Өргөмжлөл”, фемидагаар шагнуулсан байна.

А.Бямбацэемаа нь прокуророор 22 жил, орлогч прокуророор 10 жил ажиллаж байгаа прокурорын байгууллагын шилдэг боловсон хүчний нэг юм.

Прокурорын байгууллагын нийт хамт олны өмнөөс А.Бямбацэемаа танд баяр хүргэж, цаашдын ажилд нь амжилт хүсье.

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/2946